



**"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 05-р сарын 09-ний өдөр

№ 001-Т2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60, 62, 64, 65 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Мерекс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 06 сарын 20-ны өдрийн 10:00 цагт Барилга Архитектур Корпорацийн байр 4 давхар 409 тоотод ХУРАДУУЛСУГАЙ.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр ОРУУЛСУГАЙ.
 - a. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
 - b. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2022 оны 05 сарын 30-ны өдрөөр ТОГТООСУГАЙ.
4. Компанийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2022 оны 05 сарын 13 өдөр өдөр тутмын хэвлэлээр мэдээлэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс 15 хоногийн дараа буюу 2022 оны 05 сарын 30 өдөр дахин мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичигт ДААЛГАСУГАЙ.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн санал авах "Саналын хуудас"-ын агуулыг Хавсралт №1-ээр БАТАЛСУГАЙ.

Та бүхний харж мэдэж байгаачлан 2019 оноос 2021 он хүртэл санхүүгийн болон дэлхий даяар тархсан аюулт цар тахлын улмаас үйл ажиллагаа зогсонги байдалд орж алданги хүлээгээд байгаа билээ.

М.Ундрал: Тиймээ хүлээн зөвшөөр ч байна.

Н.Улаанхүү: Тиймээ хүлээн зөвшөөр ч байна.

Д.Баттулга: Тиймээ хүлээн зөвшөөр ч байна.

Ч.Жаргал: Тиймээ хүлээн зөвшөөр ч байна.

Б.Хуяг: Нийт гишүүдийн 100 хувь саналаар

1. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.

2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг хэлэлцэж шийдвэрлэв.

Хуралд оролцсон та бүгдэд баярлалаа.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах

Ногдол ашиг хуваарилахгүй байхаар тус тус шийдвэрлэв.

Хурлын дарга:



Б.Хуяг

Хурлын гишүүд:



Н.Улаанхүү

Д.Баттулга

М.Ундрал

Ч.Жаргал